

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН СЭТГҮҮЛ ЗҮЙД ХӨРШ ОРНУУДЫН
ТАЛААР ТУСГАЖ БАЙГАА НЬ

Б.Болд-Эрдэнэ*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үг: олон улсын сэтгүүл зүй, БНХАУ, ОХУ, глобал асуудал, мэдээллийн эх сурвалж, үнэлэмж

Манай судалгаагаар¹ бидний мөнхийн хөрш хоёр орон болох Орос, Хятад улсын хөгжил, эдийн засгийн өсөлт болон хамтын түншлэлийн талаарх Монголын олон нийтийн санаа бодол эерэг (68.7-90.8 хувь) дүнтэй гарсан нь мэдээллийн хэрэгслийн үр нөлөө төдийгүй цаашид хадгалагдах харилцааны суурь орчин болно. Мэдээж олон нийтийн санаа бодол нь мэдээллийн хэрэгслийн нөлөөллөөс гадна бодит амьдрал, үйл явдал үзэгдэлд тулгуурладаг, тухайн цаг үе, нөхцөл орчноо дагаж өөрчлөгддөг, нийгмийн тулгамдаж буй асуудлуудын эрэмбэ дарааллаар тодорхойлогддог зэрэг мөн чанарын үүднээс үзвэл дээр тэмдэглэсэн эерэг дүр байдал онцгой ач холбогдолтой хүчин зүйл болно. Өөрөөр хэлбэл эдийн засаг, санхүү бизнесийн хамтын ажиллагааны талаарх мэдээллийн эрэлт хэрэгцээ, нөлөө өндөр байх харилцааны орон зай бодитой оршиж байна гэсэн үг. Гэхдээ ОХУ-ын хувьд харилцан итгэлцлийн эерэг хандлагатай бол БНХАУ-ын тухайд эдийн засгийн хөгжил, бизнес арилжааны тухай мэдээлэл илүү нөлөө бүхий байгааг онцлох хэрэгтэй.

Даяарчлал, дэлхийн шинэ дэг журам, иргэншил хоорондын зөрчил, эдийн засгийн интеграцлал зэрэг орчин үеийн олон улсын харилцааны мөн чанар нь сэтгүүл зүйг илүү хариуцлагатай, тэнцвэртэй, үзэл сурталгүй мэдээллийн харилцаа байх нөхцөл шалтгаан нь болж байна. Сэтгүүл зүйн онолын томоохон төлөөлөгч Харолд Лассуел бодит үнэн нь нэгдүгээрт “баримтад үндэслэсэн” хоёрдугаарт “үнэлэмжийг агуулсан”-аар тодорхойлогдоно² гэжээ. Түүнчлэн “Сэтгүүлчид бодит байдлыг дээдлэн, үзэл бодлоо үйл явдлаас ангид үзэн хязгаарлах нь зүйтэй”³ гэсэн америкийн томоохон судлаач У.Липман тэмдэглэсэн. Олон улсын үйл явдал, амьдралын хүрээнд бодит мэдээллийн үнэ цэн нь үзэл суртал, сэтгэл хөөрөл, шууд дүгнэлт, хэтрүүлээс ангид байж, бодит баримт, үр дагавар, шалтгаанд үндэслэгдсэнээр сая эрэмбэлэгдэх болно.

Энэхүү тайлбар шалтгаанаар ч хөрш орнуудын талаарх баримт үйл явдлын сонголт, тайлбар дүгнэлтийн үндэслэл, илэрхийлэлд бодит үнэн, эрэлт хүлээлттэй, прагматик хандлагыг түлхүү баримтлах шаардлага урган гарч байна. Тиймээс Монголын олон улсын сэтгүүл зүйн тэргүүн зэргийн ач холбогдол хүрээ нь нэгдүгээрт өмнөд, хойд хоёр том хөршийн, хоёрдугаарт

эдийн засгийн нөлөө, дэмжлэг үзүүлэх улс орны, гуравдугаарт дэлхийн нийгмийн тулгамдсан, зөрчилт асуудал хэмээн ангилна. Үнэхээр ч манайх шиг дэлхийн нөлөө бүхий хоёр том гүрний дунд оршдог геополитикийн сондгой хувь тохиолдолтой үндэстэн, улс дэлхийд үгүй билээ. Тиймээс ч олон улсын үйл явдал, асуудлын мэдээллийн сонголт, үнэлэлт, тайлбарт хоёр их гүрний байр суурь нөлөөг дэлхийн нийгэм, эдийн засгийн дэг журам, хөгжил өөрчлөлттэй холбон тодотгохын сацуу үндэснийхээ эрх ашгийн үүднээс шүүн тунгаах нь чухал бөгөөд зайлшгүй мөрдлөг болж байгаа юм. Нөгөө талаас олон улсын сэтгүүл зүйн мэдээллийн ач холбогдол, үнэлэмжийг нэгд үндэсний эрх ашиг, хоёрт эдийн засаг, улс төрийн нөлөө, гуравт газарзүйн хамаарал гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогддог гэдэг. Тэр дундаа манай олон улсын мэдээллийн үнэлэмжийн хувьд үндэсний эрх ашиг нь тэргүүн зэрэгт тавигдах шалгуур юм. Үндэсний эрх ашиг нь нийгмийн ухамсар болохынхоо хувьд тодорхой асуудал, улс орон, үйл явдлын хүрээнд өөрчлөгдөн хувьсаж байдаг олон нийтийн санаа бодол хандлагын цогц илэрхийлэл юм.

Нөгөө талаар монголчуудын ихэнх хувь нь хөрш орнуудынхаа талаар дунд зэрэг ойлголт мэдээлэлтэй (орос орны талаар 58.8, хятадын тухайд 49.7 хувь) байгаа төдийгүй хятад орны талаар 41.7, хятадуудын тухай 47.4

хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь анхаарал татаж байна. Гэтэл Хятадад үйлдвэрлэсэн хувцас эдлэлийг 78,7, гэр ахуйн барааг 70.1, цахилгаан хэрэгслийг 68.2 хувь нь тус тус хэрэглэдэг хэмээн хариулжээ. Тиймээс Хятадын талаарх мэдээллийн нөлөөг дээшлүүлэх, үр ашигтай харилцааны орон зайг бий болгоход хүмүүсийн дүр сэтгэхүйд шинэ хандлага үзлийг нэмэн баяжуулах замаар үр дүнд хүрч болно. Ийм боломж нь мэдээлэл тухайн хүний дүр

сэтгэхүйд урьд өмнө нь төдий л онцлогдож байгаагүй эсвэл үзэл бодол хандлагатай нь нийцэн ямар нэг үйл явдал, үзэгдлийн талаарх төсөөлөл, ойлголтыг шинээр бий болгож байгаа үед бодитой байдаг. Ийм жишээнд хятадын аж үйлдвэрлэлийн технологийн хөгжил Германаас гүйцэн түрүүлж эхэлсэн, бүтээгдэхүүний

хяналт, шаардлага дэлхийн түвшинд эзэлж буй байр суурь зэрэг мэдээллийг тоочиж болно.

Харин Оросын соёл, аж амьдралын тухай сонирхдог гэж судалгаанд оролцогсдын 70.2, Монгол Улсын хамтын ажиллагааны талаар эерэг хүлээлттэй гэж 75.6, хоёр орны иргэдийн бизнес эрхлэх боломжийг сонирхдог гэж 65.4 хувь нь тус тус хариулт өгчээ. Өөрөөр хэлбэл Оросын нийгэм, бизнесийн хамтын ажиллагааны талаарх мэдээлэлд олон нийтийн дүр сэтгэхүйн ямар нэг агуулга, хүрээг тодотгох, илүү “гэрэлтүүлэх” замаар нөлөөлөх боломж байна гэсэн үг. Ийнхүү хэрвээ хэн нэгний дүр сэтгэхүйд



Монголын олон улсын сэтгүүл зүйн тэргүүн зэргийн ач холбогдол хүрээ нь нэгдүгээрт өмнөд, хойд хоёр том хөршийн, хоёрдугаарт эдийн засгийн нөлөө, дэмжлэг үзүүлэх улс орны, гуравдугаарт дэлхийн нийгмийн тулгамдсан, зөрчилт асуудал хэмээн ангилна



тухайн мэдээлэл эрэлт хүлээлттэй эсвэл тодорхойгүй, эргэлзээтэй үзэл ойлголтыг тодотгох аваас харилцаа үр нөлөөтэй болж, шинэ хандлага, байр суурийг бий болгож, үл мэдэх байдлыг нь багасган, нөлөө үзүүлэх нь дамжиггүй билээ.

Ер нь Монголчуудын хувьд ОХУ-ын тухай мэдээлэл илүү сонирхолтой, чухал байгаа нь бидний судалгаагаар нотлогдсон. Тиймээс ч хүн өөрийн дүр сэтгэхүйд нийцсэн мэдээллийг илүү ойлгож, үзэл бодол, итгэл үнэмшил, үнэлэмж хандлагыг нь бататгасан утга агуулгын нөлөөнд автдаг зүй тогтол ОХУ-ын тухай мэдээлэлд бодитой оршиж байна. Мэдээж өөрийн дүр сэтгэхүйд үл нийцсэн харилцаанд хүн үгүйсгэгч сөргөлдөгч байр сууринаас хандах, эсвэл эсрэг баримт нотолгоог эрэлхийлэх, тухайн мэдээллийн эх сурвалжийг шүүмжлэх, эргэлзэх бүр болохгүй бол “зугтах” хариу үзүүлдэг байна. Цаашилбал мэдээлэл нь хэдий чинээ хүний дүр сэтгэхүйн хандлага, үзэл баримтлал, ертөнцийг үзэх үзэлд зонхилогч байр суурьтай байна, төдий чинээ үгүйсгэл эсэргүүцэл хүчтэй байх болно. Үнэхээр ч судалгаанд оролцогсдын 57 хувь нь хятадын соёл, ёс заншил, аж амьдралыг сонирхдоггүй, 61.5 хувь нь ажиллаж амьдрахыг хүсдэггүй, 53.8 хувь нь бизнес хамтрагчийг эрэлхийлдэггүй гэсэн хариулт өгсөн нь урьдач дүр төсөөлөл сөрөг, зөрчилт байгаатай холбоотой. Монголчууд эртнээс өмнөд хөршөөсөө эмээдэг, үл итгэдэг, сөрөг сэтгэлзүйн хандлагатай төдийгүй ахуй, орчин, соёл, амьдралын хэв маягийг ойлгодоггүй, үл хэрэгсдэг зан сэтгэлгээтэй үндэстэн билээ. Тиймээс өрнийн олон нийтийн харилцааны онолын үүднээс үзвэл, дээрх сөрөг хандлага нь хувь хүний дүр сэтгэхүйн үнэлэмж, үнэт

чанартай зөрчилдсөн мэдээлэл хүчтэй үгүйсгэл, эсэргүүцлийг өдөөдөг мөн чанарт шалтгаан нь оршиж байна. Өөрөөр хэлбэл, үнэлэмжийн тогтолцоо нь хүний дүр сэтгэхүйн хамгийн чухал орон зай, хандахуй бөгөөд түүний бүхий л төсөөлөл ойлголтын эх сурвалж болно гэсэн үг. Энэ тухай К.Дейвисон “харилцааны үр нөлөө нь бие хүний мэдээлэлд хандах дүр байдлын үнэлэмжээс шалтгаалдаг”⁴ болохыг, Д.Баулинг “бие хүний үнэлэмжийн давхарга, эсвэл систем нь хамгийн чухал бие даасан үр нөлөөг тодорхойлогч хүчин зүйл”⁵ гэж онцолсон нь бий.

Тэгэхлээр Хятадын тухай мэдээлэл нь соёл, үнэлэмжийн агуулгыг бус харин хэрэглээ, технологи, зан чанарын тухайд байж сая эерэг нөлөө үзүүлнэ. Манай судалгаанд оролцогсдын 75.8 хувь нь хятадуудын ажилч хичээнгүй байдлыг, 62.9 хувь нь арвич хямгач чанараас суралцах хэрэгтэй гэж хариулсан нь ч дээрх дүгнэлтийг нотолж байна. Харин оросуудын хувьд үнэнч шударга зангаас нь суралцах хэрэгтэй хэмээн 69.3, найрсаг зочломтгой байдлыг нь дээдэлдэг гэж 65.9, эх оронч 69.8, хүний эрх чөлөөг дээдэлдэг 60.3 хувь нь тус тус хариулжээ. Хөрш хоёр орны талаарх Монголчуудын дүр сэтгэхүйг (стереотип) харахад хятадуудын хувь зан чанарт эргэлзсэн, үл мэдэгч байдал (үнэнч шударга эсэхийг мэдэхгүй 50, энгийн гүндүүгүйг хэлж мэдэхгүй 53.9, цайлган эсэхийг мэдэхгүй 52.8 хувь ялгаварлан гадуурхдаг эсэхийг мэдэхгүй 51.8 хувь) давамгайлж байгаа бол оросуудыг илүү эергээр хүлээж авдаг дүр зураг гарчээ.

Ер нь харилцааны бүхий л хүчин зүйл болох эх сурвалж, суваг хэрэгсэл, утга агуулга, хүртэгсдийн шинж чанар,

орчин, харилцаанд өдөөгдөхөөс өмнөх болоод дараах үр дүн гээд бүхэлдээ мэдээлэлд агуулагдаж, түүнд нэгтгэгдэн оршдог учиртай. Эдгээр хүчин зүйл нь ч хувь хүний дүр сэтгэхүйн ямар нэгэн үзэл, хандлагыг өдөөх, эрэлт сонирхлыг идэвхжүүлэх, аль нэг үнэлэмжийг нь тодотгох, ойлголцлын хүрээг бий болгох, харилцааны үүрэг, үр дагаврыг тодорхойлох гээд мэдээллийг ойлгох, утга агуулгыг нээх, улмаар түүний нөлөөнд орох учир шалтгаан, нөхцөл нь болдог байна.

Тиймээс хөрш орнуудын талаарх Монголын ОНМХ-ийн мэдээлэл нийтлэл нэвтрүүлэг хангалтгүй нийгэм, иргэдийн эрэлт хэрэгцээ, сонирхлыг хангаж чадахгүй байна гэж дүгнэж болно. Монголын олон улсын сэтгүүл зүй нь хүйтэн дайны үед үзэл суртлын хүрээнд төлөвшин тогтсон, эсрэг тэсрэг зөрчилт байр сууринаас асуудлыг үнэлж тайлбарлаж ирсэн уламжлал өдгөө хүртэл хадгалагдсаар байна. Энэ нь ч бодит, үнэ цэнтэй мэдээллийн орон зайг бий болгож чадахгүй байгаагийн шалтгаан мөн.

Гэтэл 1990-ээд оноос дэлхий нийгэм, олон улсын харилцаанд үзэл суртал, улс төрийн бүлэглэл сөрөн эсэргүүцэх, заналхийлэх хандлага үгүй болж, харилцан ойлголцох, ургалч үзэл бодол, байр суурийг дээдлэх болсноор мэдээллийн орон зайд урьд өмнө байгаагүй боломж, өнгө төрхийг бий болгосон нь олон улсын сэтгүүл зүйн мөн чанар, үүрэг зорилгыг шинэчлэн

үзэх шалтгаан болсон юм. Үүнийг томъёолбол олон улсын сэтгүүл зүй нь дэлхийн нийгэм, улс орнуудын үйл явдал үзэгдэл тулгамдсан асуудлын тухай мэдээллийг үндэсний язгуур эрх ашиг, үнэлэмжийн үүднээс хүлцэн тэвчих, хүмүүнлэг эш байдалд тулгуурлан түгээх зорилго бүхий харилцаа хэмээх болов. Өөрөөр хэлбэл олон улсын сэтгүүл зүйг дэлхийн нийгмийн харилцаа хэмээн тодорхойлох болсон нь улс төр-үзэл суртлын хатуу чанд хязгаарлалтаас

хүлцэн тэвчихүй, уруу, марксист ангич, намч байр сууринаас иргэншил, улс үндэстний эрх ашгийн тайлбар уруу, нэг талын, тулган шахалтын сэтгэхүйгээс ургалч, харилцан ойлголцол руу мэдээллийн орон зайн хувьсан шинэчлэгдсэн гэсэн үг. Энэхүү олон улсын сэтгүүл зүйн шинэ төлөв байдалд нөлөөлөгч

олон хүчин зүйл, үндэслэл шалтгаан бий боловч тэдгээрийг нэгтгэн зургаан хүрээнд авч үзсэн нь бий. Үүнд шинэ түүхэн цаг үе, улс төрийн шинэ газрын зураг, даяарчлалын сэтгэлгээ, сэтгүүл зүйн шинэ агуулга болон хэрэглэгчид (үзэгч, сонсогч, уншигч, зохиогч) эдгээр болно гэжээ. Үнэхээр ч хүйтэн дайны үед АНУ, ЗХУ гэсэн хоёр том гүрэн, сөргөлдөгч талын үзэл суртал, номлолоор олон улсын амьдралын үйл явдал үзэгдлийг тайлбарлаж дүгнэж байсан нь дэлхийн мэдээллийн орон зайг төөрөгдүүлэлтээр дүүргэж, асуудлын учир шалтгаан, мөн чанарыг үнэлж дүгнэх бус харин үгүйсгэл, туйлшрал эсхүл магтаалын сэтгүүл зүй болохын үндэс



Олон улсын сэтгүүл зүй нь дэлхийн нийгэм, улс орнуудын үйл явдал үзэгдэл тулгамдсан асуудлын тухай мэдээллийг үндэсний язгуур эрх ашиг, үнэлэмжийн үүднээс хүлцэн тэвчих, хүмүүнлэг эш байдалд тулгуурлан түгээх зорилго бүхий харилцаа



шалтгаан болов. Ийм жишээ хандлага монголын сэтгүүл зүйн өнгөрсөн төдийгүй өдгөө цагийн агуулга хандлагад ч оршсоор байна.

Үнэхээр бид социалист интернационализмийг даяарчлалаар, ЗХУ-ыг АНУ-аар, социалист орнуудын ололт амжилтыг ертөнцийн дуулиан шуугианаар, хамтын ажиллагаа, тусламжийг нь хандивлагч орнуудын зээлээр сольсноос өөр өөрчлөлт үгүй олон улсын сэтгүүл зүйтэй ч болжээ. Гэтэл Монголын нийгэм, хэрэглэгчдэд үндэсний эрх ашиг, сонирхлыг дэлхийн нийгмийн шинэ дэг журамд бодитой үнэлж дүгнэгч сэтгүүл зүй юу юунаас чухал гэдэг нь ойлгомжтой. Энгийнээр хэлбэл манай олон улсын сэтгүүл зүй нь дэлхий ертөнцийг харах “монгол цонх” байх ёстой. Харилцааны орон зайн өөрчлөлт, цаг үеийн нөхцөл байдал хүний мэдээллийн эрэлт хэрэгцээ төдийгүй дүр сэтгэхүй, хандлагыг өөрчлөгч хүчин зүйл мөн. Энэхүү үр нөлөө нь уг хүний хувьд урьд өмнөх ойлголт, үзэл хандлага өөрчлөх эсвэл нягтлах зайлшгүй нөхцөлд (Хятад дэлхийн эдийн засгийн хоёр дахь хүч болсон зэрэг), эсвэл буруу, зөрчилтэй байр суурь, төсөөлөлтэй байсныг нотолсон мэдээлэл (ОХУ-ын дэлхийн бодлогод нөлөөлөх байр суурь Ойрх Дорнодын үйл явдлаар өсөн нэмэгдсэн зэрэг) хүлээн авсан үед бий болдог байна.

Ер нь хүн ч тэр, үндэстэн ч адил мэдээллийг нийгэм болон байгаль ертөнцийн талаарх үзэл ойлголт, төсөөллөө эмхлэх зорилгоор эрэлхийлдэг ба хэрэв тэрхүү гадаад орчин нь өөрчлөгдвөл мэдээллийн эрэлт сонирхол, итгэн үнэмших магадлал нь өсдөг жамтай болно. Нийгэм болон байгалийн гадаад орчны өөрчлөлт нь хүний дотоод ертөнцийн дүр сэтгэхүйг тогтворгүй

болгодог ба эргэлзээ, түгшүүрийг өдөөдөг. Тиймээс ч хүн өөрийн дүр сэтгэхүүдээ дахин эмхлэх, бататгах мэдээллийг эрэлхийлдэг болой. Мэдээж энэхүү үйл явдал бүрд хандах олон нийт, нийгмийн хандлага өөр өөр боловч дүр сэтгэхүүгээ өөрчлөх мөн чанар, эрэлт хэрэгцээ нь нэгэн адил шалтгаантай байсан билээ. Ерөнхийлөн дүгнэвэл харилцааны орчин нь бүхэлдээ хүний ч тэр, олон нийтийн ч тэр дүр сэтгэхүйг өөрчлөгч хамгийн гол зүйл болж байна. Үүнийг ч өмнөх тайлбар дүгнэлтүүдэд дурдсан билээ. Мэдээллийн үр нөлөө ч хүний тухайн дүр сэтгэхүүд нийцэж байсан нөхцөл орчин, бодит байдал нөгөөгөөр өөрчлөгдсөнийг тодотгосон үе, тохиолдолд бодитой болдог ажээ. Сүүлийн үеийн хөрш орнуудын хүрээнд л гэхэд АНУ Хятадын худалдааны дайн, Оросын байгалийн хийн хоолойн мега төслүүд, ОХУ-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны эрс тэлэлт зэрэг онцгой үйл явдал, үзэгдэл нь монголын олон нийтийн мэдээллийн эрэлт сонирхол гадаад орчны өөрчлөлт, нөлөөгөөр эрс өсөж байх жишээтэй.

Монголын нийгэм, олон нийт хөрш хоёр орны талаарх мэдээлэл нийтлэл нэвтрүүлгийг телевиз (81 хувь), интернэт (63.2 хувь), нийгмийн сүлжээ (57.5 хувь) гэсэн суваг хэрэгслээр хүлээн авдаг гэжээ. Цаашилбал 23.7 хувь нь сонин хэвлэлээс, 23.7 хувь нь тухайн улсын кино, нэвтрүүлгээс, 21.8 хүмүүсээс (тухайн улсад сурч ажиллаж буй) 13.6 нь радиогоос, 3.2 нь ЭСЯ, консулын тус тус мэдээлэл авдаг байна. Үүний шалтгаан нь юуны өмнө хүмүүсийн мэдээллийн эрэлт хэрэгцээ, ханамж нь бага хүчин чармайлтаар илүү их утга агуулга, эсвэл хэрэглээнд нийцсэн дадал хэвшилд нь ойр арга хэлбэрээр мэдээллийг олж авснаар тодорхойлогддог мөн чанартай холбоо-

той. Тэгээд ч хүний харилцааны зорилго, эрмэлзэл нь мэдээлэл ямар ч байсан, нарийн төвөгтэй утга агуулгынх ч байсан хялбар байдлаар ойлгоход чиглэдэг. Орчин үеийн хүн дүрст (визуаль), хаа сайгүй хэзээ ч хэрэглэж болох хувь хүний хайлт, дахин дамжуулал, “Би” төвт мэдээллийн хэрэгслийг ашиглах эрмэлзэл хандлагатай болсон нь мобайл сэтгүүл зүйн түрэлтийн үндсэн шалтгаан юм. Өөрөөр хэлбэл мэдээллийн нөлөөнд хэрэгслийн технологийн хөгжил, давуу тал, хэрэглээний шинэ хэлбэр тэргүүлэх байр суурьтай байна гэсэн үг.

Хөрш орнуудын талаарх олон нийтийн санаа бодлын өөр нэгэн асуудал нь орос, хятад хүний тухай монголчуудын хэв шинжит дүр төсөөлөл (стереотип) юм. Нөгөө талаар ОНМХ-ээр түгээгдэж буй мэдээлэл нь үйл явдал үзэгдлийн “мөсөн уул”-ын орой бөгөөд асуудлын мөн чанар, шалтгааныг бүрэн дүүрэн хүргэх боломж нөхцөл ч хязгаарлагдмал бас хүү нийгэм олон нийт ч түүнийг хянах боломж гэж үгүй. Тэгээд ч У.Липман хүмүүсийн бодит байдлын талаарх дүр төсөөллийг ОНМХ-ээр бий болсон, “нийтийн төөрөгдөл” хэмээн томъёолж, түүнийгээ хэв шинжит дүр төсөөлөл хэмээсэн байх юм.

Бидний хийсэн судалгаагаар Монгол улсад ажиллаж, бизнес эрхэлж буй хятад хүний талаарх дүр төсөөлөл сөрөг, харин орос хүнийх тодорхойгүй болох нь харагдаж байна. Тухайлбал хятад хүн Монголын байгалийг сүйтгэдэг гэж 66.4, чанаргүй барааг өндөр үнээр борлуулдаг гэж 69.4, монголчуудыг дорд үздэг хэмээн 65.5, мансуурах хэрэглээ, биеэ үнэлэлтийг тэтгэдэг гэж 65.2, авлига өгдөг гэж 63, залилан мэхлэгч хэмээн 61.2 хувь нь тус тус хариулт өгчээ. Харин дээрх асуултад

орос хүний хувьд мэдэхгүй 43.9-52.4 хувь нь хариулжээ. Нэн ялангуяа Монголын ёс заншил уламжлалыг үл тоомсорлодог эсэх тухай асуултад Хятадын эсрэг 58.6 хувь нь хариулт өгсөн мөртлөө орос хүний хувьд хүндэлдэг гэж 39.8 мэдэхгүй хэмээж 40.6 хувь нь хариулжээ.

Мэдээж энэхүү дүр төсөөлөл нь (стереотип) зөрчилтэй, бүрэн дүүрэн бус ч хүн гэгч түүндээ үнэнч, бөгөөд хэвшиж дадсан байдаг. Тийнхүү хүн таньж мэддэг, ухаарч ойлгосон ертөнцийнхөө дүр төсөөллийнхөө хүлээлтээр буюу нэгэнт бий болгосон загвараар сэтгэдэг. Өөрөөр хэлбэл хэв шинжит дүр төсөөлөл бол бидний мэдрэмж, өөрийн ертөнцийн өмнө хүлээсэн хариуцлага, зан байдал, дадал зуршлын баталгаа болдог. Нөгөө талаар хэв шинжит дүр төсөөлөл нь хувь хүний болоод олон нийтийн, цаг үеэ ойлгож тодорхойлох үндсэн шалгуур, хүчин зүйл болой.

Тиймээс зөвхөн гадаад мэдээ төдийгүй улс орны дотоод амьдрал үйл явдлын тухай тайлбар, ярилцлагад ч хөрш орны тухай дүр төсөөлөл төлөвшин бий болдог. Дээр өгүүлсэн Хятадын талаарх сөрөг дүр төсөөлөл нь уул уурхайн ашигт малтмал барилга, зам гүүр, гадаад худалдаа зэрэг монголын эдийн засгийн гол чухал салбарт өмнөд хөршийн оролцоо, нөлөө хэт давамгайлж байгаа, төрийн бодлого хяналт сул, авлигад хэт автсан, ядуурал ажилгүйдэл буурахгүй байгаа зэрэг асуудлын шалтгааныг манай эрх баригчид төдийгүй ОНМХ-үүд гадаад хүчин зүйлтэй холбон тайлбарлаж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл нийгмийн тэргүүлэгч үзэл бодолд өмнөд хөршөө буруутгах, эмээх, үгүйсгэх хандлага давамгайлж байна гэсэн үг.

Лазарсфельд, Кац⁶ нарын судлаачид “хоёр үе шаттай урсгал” хэмээх олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөө нийгмийн тэргүүлэгч үзэл бодлоор дамжин (шүүгдэн) олон нийтэд хүрдэг тухай онолоо дэвшүүлсэн нь хүмүүс хоорондын болоод олон нийтийн харилцааны уялдаа холбоог тодорхойлох чухал үндэслэл юм. Товчхондоо бол лидерийн үг үзэл санаа хүмүүст нийгмийн тэргүүлэгч үзэл мэт ойлгогдож нөлөөлдөг гэсэн үг. Тиймээс ОНМХ-ийн үр нөлөө нь хүмүүс хоорондын харилцаагаар дамжин бодит зүйл болж, мэдээлэл нь нийгмийн үйл явдал, амьдралын учир шалтгаан мөн чанарыг шийдвэрлэх, яагаад тийм зүйл болсныг хариулахад бус, харин асуудлыг нээн, олон нийтийн анхаарлыг өдөөх зорилго, агуулгатай байх болно.

Гэтэл Монголын ОНМХ нь аливаа зөрчил, сорилт, хямралын шалтгааныг шууд дүгнэдэг, шийдвэр гарцыг зааж өгдөг буруу хандлагатай бөгөөд ингэхдээ ихэнх байр суурь, тайлбар нь төр засгийн оролцоог дээдэлсэн, бусдыг буруутгасан (үүнд өмнөд хөрш багтана) олон нийтийг сохроор өргөмжилж байна. Ийнхүү дүгнэж буй шалтгаан нь манай судалгаанд оролцогсдын 73 хувь нь хятадуудтай хамтарч бизнес хийж үзээгүй, 76.4 нь өмнөд хөршид сурч ажиллаж байгаа гэр бүлийн гишүүн үгүй, 76.8 хувь нь хамаатан садан нь хотод сурч ажиллаагүй, 70.8 нь найз нөхөд танилын харилцаа байхгүй гэж хариулсан байгаад оршино.

Өөрөөр хэлбэл бодит амьдрал, нийгмийн хүрээнд шууд холбоо харилцаа үгүй боловч сөрөг дүр төсөөлөл, үзэл бодолтой байгаа нь мэдээллийн хэрэгслийн нөлөө, лидер, эрх баригчдын дүгнэлт тайлбараас шалтгаалж байна гэх бүрэн үндэстэй

юм. Нөгөө талаар оросуудын хувьд ч 74.8 хувь нь хамтарч бизнес эрхэлдэггүй, 71 хувь нь гэр бүлийн юм уу ойр дотнын хүн нь тус улсад ажиллаж сураагүй, 49.1 нь ямар нэгэн холбоо харилцаагүй гэж хариулсан өмнөд хөршийнхтэй адил ойролцоо дүр зураг харагдаж байгаа боловч сөрөг хандлага үгүй байна.

Гэхдээ монголчуудын хувьд хөрш хоёр оронтой найрсгаар харилцах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэл сонирхол байгаа нь судалгаанд оролцогсдын 52.2 хувь нь бүх талаар хамтрагч байх боломжтой, 21.4 хувь нь ажил бизнесийн хүрээнд ажиллах сонирхолтой хэмээн хариулсан дүнгээс харж болно. Нэн ялангуяа хойд хөрштэй дэд бүтэц, барилга, эрүүл мэнд хүнд үйлдвэрлэл, батлан хамгаалах салбарт (65-73 хувь орчим) хамтран ажиллах, хөрөнгө оруулалт татахыг дэмжиж байна. Өмнөд хөршийн хувьд дээрх үзүүлэлт харьцангуй бага ч 50-иас дээш хувьтай бас мэдэхгүй гэсэн хариулт 20-30 хувийг эзэлж байна. Нөгөө талаар хоёр хөршийн эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагаанд Монголын зах зээл жижиг (52.8-58 хувь) төрийн хүнд суртал авлигал саад болж байна (48.9-52 хувь) хөрөнгө санхүүгийн чадавхгүй байдал (44.9-48.6 хувь) дэд бүтцийн хөгжил дорой (46.9-49.7 хувь) зэрэг хүчин зүйл сөргөөр нөлөөлдөг хэмээн бодит үнэнийг хүлээн зөвшөөрч байгаа нь гадаад мэдээлэл харилцааны стратеги, агуулга илэрхийлэлд бодох ёстой үзүүлэлт болно.

Манай судалгаанд оролцогсдын 76.4 хувь нь ОХУ-тай, 69.8 нь БНХАУ-тай хамтын ажиллагаа, харилцааны бүхий л хүрээнд эерэг дэвшил гарна гэж өөдрөгөөр хүсэн хүлээж байгаагаа илэрхийлсэн нь ОНМХ-ийн нийгмийн санаа бодлыг баталгаажуулагч, нэгтгэн

тодотгогч үр нөлөөний бодитой үндэс суурь хэмээн үзэж байна. Ер нь ОНМХ-ийн үр нөлөөний бодит жинхэнэ шалтгаан нь олон нийтийн нэгэнт тогтсон урьдач байр суурь хандлагаас шууд хамаардаг бөгөөд тодорхой үйл явдал асуудалд нийгмийн анхаарлыг төвлөрүүлэх, сорилт зөрчил бэрхшээлийг нээн тодотгоход оршдог гэж үздэг. Тиймээс Монголын олон улсын сэтгүүл зүйд хоёр хөрш орныхоо үйл явдал, бодлого байр суурийг эдийн засаг, хөрөнгө оруулалт, нийгмийн хүрээнд үндэсний эрх ашиг, олон нийтийн санаа бодлын эерэг хүлээлт, хандлагад нийцүүлэн мэдээлэл нийтлэл нэвтрүүлэх бодлого стратегиа тодорхойлох зайлшгүй шаардлага урган гарч байна. Энэ нь зорилго болоод үр нөлөөний талаасаа ч хамгийн бодитой, үнэ цэнтэй зарчим төдийгүй Монголын сэтгүүл зүйн онцлог, мөн чанар билээ.

Эшлэл

- ¹ "Хөрш орнууд, тэдгээрийн ард олны талаарх Монголын олон нийтийн санал бодол" МУИС-ийн ШУС-ийн НУС, ОУХНУС-ийн хамтарсан судалгаа
- ² Harold Lasswell "Process and Effect of Mass Communication" NY. 1948.
- ³ Walter Lippmàn "Liberty and the News" NY. 1920. p. 82.
- ⁴ Deiwison K. Mass Communication Theory: An Introduction. L., 1977, p. 156
- ⁵ Bowling D. The effects of Mass communication. N.-Y., 1960, p. 61.

- ⁶ Lazarsfeld P.F., Katz E. Personal Influence. The Part Played by People in the Flow of Communications. N.-Y., 1955.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Хөрш орнууд, тэдгээрийн ард олны талаарх Монголын олон нийтийн санал бодол. МУИС-ийн ШУС-ийн НУС, ОУХНУС-ийн хамтарсан судалгаа.
2. Bowling D. The effects of Mass communication. NY., 1960.
3. Deiwison K. Mass Communication Theory: An Introduction. L., 1977.
4. Harold Lasswell. Process and Effect of Mass Communication. NY. 1948.
5. Lazarsfeld P.F., Katz E. Personal Influence. The Part Played by People in the Flow of Communications. NY., 1955.
6. Walter Lippmàn. Liberty and the News. NY. 1920.

Summary

In this article, the author defines international journalism as a relationship that aims to tolerate information about world society and countries and issues from the perspective of fundamental national interests and values, and to disseminate them based on humane prophecy. On this basis, Mongolia's priority areas of international journalism are classified as, firstly, the problems of its two big neighbors to the south and north, secondly, the economic influence and support of the country, and thirdly, the problems of the world society. Improving Mongolia's international journalism is considered in terms of ethnicity and communication.